**ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

# Хөвсгөл аймгийн Түнэл сумын эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ХӨА-2026/060/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Мөрөн сум<br>2026 он | Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,<br>тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар<br>Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn<br>Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр<br>Утас: 99089114 Цахим хаяг:tegshdelgerb@audit.gov.mn<br>Аудитор: Г.Ичинхорлоо<br>Утас:88688168 Цахим хаяг: ichinkhorloog@audit.gov.mn<br>Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа<br>Утас:99389208 Цахим хаяг: b_myadagmaaa@yahoo.com<br>Аудитор Ц.Мөнхтуяа<br>Утас: 99382220 Цахим хаяг: munkhtuya2220@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ


ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn


2026.02.25 № 01/243

танай ____________-ны № ____________-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТҮНЭЛ
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.ГҮНДМАА ТАНАА

## Хараат бус аудиторын дүгнэлт

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Түнэл сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Түнэл сумын Эрүүл мэндийн төв нь тайлант онд Эрүүл мэндийн даатгалын сангаас авах 19,206.3 мянган төгрөгийг санхүүжилтийн авлагаар бүртгэсэн байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар нийт 16,883.1 мянган төгрөгийн 8 алдаа, зөрчил илрүүлж, 7,683.8 мянган төгрөгийн 6 алдааг залруулж, үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаж, үнэлгээг шинэчлэн тогтоох 1 зөвлөмж өгч, 9,199.3 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүллээ.

**Бусад асуудлын хэсэг**

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас Түнэл сумын Эрүүл мэндийн төвтэй байгуулсан анхан шатны тусламж үйлчилгээг худалдан авах 2025 оны гэрээний биелэлтийг 95.1 хувьтай дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А. ЭРДЭНЭБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **429,177,308.28** | **459,477,136.75** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 47,676,233.23 | 107,854,888.87 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 47,676,233.23 | 107,854,888.87 |
| **3121** | **Төгрөг** | 47,676,233.23 | 107,854,888.87 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 47,676,233.23 | 107,854,888.87 |
| **33** | **АВЛАГА** | 189,899,157.02 | 146,386,029.33 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 189,899,157.02 | 146,386,029.33 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | 00.00 | 4,200,800.00 |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | 00.00 | 4,200,800.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 191,601,918.03 | 201,035,418.55 |
| **351** | **Түүхий эд материал** | 92,641,532.43 | 82,461,100.43 |
| 35130 | Эм боох материал | 92,641,532.43 | 82,461,100.43 |
| **354** | **Хангамжийн материал** | 98,960,385.60 | 118,574,318.12 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 6,689,040.10 | 5,514,996.10 |
| 35420 | Аж ахуйн материал | 45,431,068.00 | 61,794,402.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 00.00 | 810,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 00.00 | 175,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 12,213,067.50 | 19,518,720.02 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 34,627,210.00 | 30,761,200.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,450,425,500.44** | **1,437,292,431.00** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,450,425,500.44 | 1,437,292,431.00 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,432,780,700.44 | 1,419,806,031.00 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,327,071,414.00 | 1,361,740,590.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -182,594,756.60 | -205,694,599.58 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 135,260,556.00 | 135,260,556.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -39,512,727.74 | -58,352,246.26 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 275,022,666.00 | 302,552,566.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -95,225,321.41 | -128,682,052.09 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 37,686,443.00 | 41,126,443.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -24,927,572.81 | -28,145,226.07 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 17,644,800.00 | 17,486,400.00 |
| 39301 | Програм хангамж | 792,000.00 | 792,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -475,200.00 | -633,600.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 17,328,000.00 | 17,328,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,879,602,808.72** | **1,896,769,567.75** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,879,602,808.72** | **1,896,769,567.75** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,879,602,808.72 | 1,896,769,567.75 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 148,642,601.00 | 148,642,601.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 148,642,601.00 | 148,642,601.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 1,710,764,514.58 | 1,727,931,273.61 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,710,764,514.58 | 1,710,764,514.58 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 17,166,759.03 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 20,195,693.14 | 20,195,693.14 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,879,602,808.72** | **1,896,769,567.75** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,301,228,889.70** | **1,336,972,857.34** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **174,872,978.91** | **172,208,645.54** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 174,872,978.91 | 172,208,645.54 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 174,872,978.91 | 172,208,645.54 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 29,472,000.00 | 97,179,964.80 |
| 1200017 | Үнэ төлбөргүй хүлээж авсан орлого-үндсэн хөрөнгө | 118,882,503.00 | 57,669,176.00 |
| 1200018 | Үнэ төлбөргүй хүлээж авсан орлого-бараа материал | 26,518,475.91 | 17,359,504.74 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,126,355,910.79** | **1,164,764,211.80** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 40,229,200.00 | 48,670,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 40,229,200.00 | 48,670,300.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 1,086,126,710.79 | 1,116,093,911.80 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 1,086,126,710.79 | 1,116,093,911.80 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,152,552,668.13** | **1,319,806,098.31** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,152,552,668.13** | **1,319,806,098.31** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,122,610,758.90 | 1,222,694,830.15 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 687,282,517.77 | 819,290,048.71 |
| 210101 | Үндсэн цалин | 391,988,400.59 | 400,085,187.00 |
| 210102 | Нэмэгдэл | 219,385,255.01 | 280,355,804.21 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 17,915,618.86 | 48,441,520.79 |
| 210104 | Урамшуулал | 56,965,689.71 | 90,407,536.71 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 1,027,553.60 | 00.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 85,411,805.08 | 103,688,194.77 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 60,383,223.59 | 77,004,959.34 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,061,330.04 | 8,057,099.69 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,917,027.94 | 4,264,974.79 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,022,515.57 | 2,894,206.84 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,027,707.94 | 11,466,954.11 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 36,759,290.77 | 47,266,353.51 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,280,264.97 | 4,244,209.51 |
| 210302 | Түлш, халаалт | 31,979,025.80 | 43,022,144.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,500,000.00 | 00.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 84,358,438.75 | 43,581,613.97 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,924,400.00 | 8,187,454.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 18,599,020.00 | 18,876,770.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,640,000.00 | 2,640,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,045,540.00 | 3,480,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 9,112,750.00 | 5,812,010.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 14,220,303.00 | 00.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 29,816,425.75 | 4,585,379.97 |
| **2105** | **Нормативт зардал** | 84,005,690.68 | 84,066,909.75 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 70,478,013.68 | 65,758,012.27 |
| 210502 | Хоол, хүнс | 13,527,677.00 | 18,308,897.48 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 11,899,900.00 | 6,969,870.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 00.00 | 1,200,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 11,899,900.00 | 5,769,870.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,774,000.00 | 7,190,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,774,000.00 | 7,190,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 47,003,518.50 | 31,719,694.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 46,829,100.00 | 30,336,400.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 1,152,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 00.00 | 86,450.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 114,108.50 | 58,474.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 00.00 | 53,800.00 |
| 210807 | Газрын төлбөр | 60,310.00 | 32,570.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 81,115,597.35 | 78,922,145.44 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,434,000.00 | 150,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 73,681,597.35 | 78,772,145.44 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 29,941,909.23 | 97,111,268.16 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 29,472,000.00 | 95,707,321.67 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 54,151,321.67 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 29,472,000.00 | 41,556,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 469,909.23 | 1,403,946.49 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 469,909.23 | 1,403,946.49 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **148,676,221.57** | **17,166,759.03** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **148,676,221.57** | **17,166,759.03** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **980,030,609.77** | **1,305,457,304.29** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **29,472,000.00** | **97,179,964.80** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 29,472,000.00 | 97,179,964.80 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 29,472,000.00 | 97,179,964.80 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 29,472,000.00 | 97,179,964.80 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **950,558,609.77** | **1,208,277,339.49** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 40,229,200.00 | 48,670,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 40,229,200.00 | 48,670,300.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 910,329,409.77 | 1,159,607,039.49 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 910,329,409.77 | 1,159,607,039.49 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,007,422,642.75** | **1,237,308,748.65** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,007,422,642.75** | **1,237,308,748.65** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **977,480,733.52** | **1,140,197,480.49** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 687,282,517.77 | 819,290,048.71 |
| 210101 | Үндсэн цалин | 391,988,400.59 | 400,085,187.00 |
| 210102 | Нэмэгдэл | 219,385,255.01 | 280,355,804.21 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 17,915,618.86 | 48,441,520.79 |
| 210104 | Урамшуулал | 56,965,689.71 | 90,407,536.71 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 1,027,553.60 | 00.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 85,411,805.08 | 103,688,194.77 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 60,383,223.59 | 77,004,959.34 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,061,330.04 | 8,057,099.69 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,917,027.94 | 4,264,974.79 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,022,515.57 | 2,894,206.84 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,027,707.94 | 11,466,954.11 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 36,759,290.77 | 47,266,353.51 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,280,264.97 | 4,244,209.51 |

| | | | |
|---|---|---|---|
| 210302 | Түлш, халаалт | 31,979,025.80 | 43,022,144.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,500,000.00 | 00.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 27,654,550.00 | 52,063,580.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,717,230.00 | 3,951,910.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 18,599,020.00 | 23,077,570.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,640,000.00 | 2,640,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 5,114,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,698,300.00 | 17,279,600.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 67,609,051.40 | 61,054,239.50 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 52,529,471.40 | 40,112,689.50 |
| 210502 | Хоол, хүнс | 12,279,580.00 | 20,941,550.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,800,000.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 9,862,700.00 | 9,300,870.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 00.00 | 3,356,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 9,862,700.00 | 5,944,870.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,774,000.00 | 7,190,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,774,000.00 | 7,190,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 50,692,818.50 | 32,145,694.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 49,072,100.00 | 30,556,400.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,152,000.00 | 1,152,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 00.00 | 86,450.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 114,108.50 | 58,474.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 00.00 | 53,800.00 |
| 210807 | Газрын төлбөр | 60,310.00 | 32,570.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 294,300.00 | 206,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 7,434,000.00 | 8,198,500.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,434,000.00 | 8,198,500.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **29,941,909.23** | **97,111,268.16** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 29,472,000.00 | 95,707,321.67 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 54,151,321.67 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 29,472,000.00 | 41,556,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 469,909.23 | 1,403,946.49 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 469,909.23 | 1,403,946.49 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-27,392,032.98** | **68,148,555.64** |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **4** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)** | **00.00** | **00.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **9,863,200.00** | **7,969,900.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **9,863,200.00** | **7,969,900.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 9,863,200.00 | 7,969,900.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 9,863,200.00 | 7,969,900.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-9,863,200.00** | **-7,969,900.00** |
| | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | -37,255,232.98 | 60,178,655.64 |
| **9** | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 84,931,466.21 | 47,676,233.23 |
| **10** | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 47,676,233.23 | 107,854,888.87 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

/ төгрөгөөр /

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|
| 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 148,642,601.00 | 20,195,693.14 | 1,559,035,014.99 | 1,727,873,309.13 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 3,053,278.02 | 3,053,278.02 |
| 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 148,642,601.00 | 20,195,693.14 | 1,710,764,514.58 | 1,879,602,808.72 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 17,166,759.03 | 17,166,759.03 |
| 2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 148,642,601.00 | 20,195,693.14 | 1,727,931,273.61 | 1,896,769,567.75 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**
**Улсын төсвийн гүйцэтгэл:**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **1** | **НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН** | **1,427,645,100.00** | **1,256,787,004.29** | **170,858,095.71** | **88.03** |
| **12** | **Татварын бус орлого** | **1,427,645,100.00** | **1,256,787,004.29** | **170,858,095.71** | **88.03** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 96,471,500.00 | 97,269,964.80 | -798,464.80 | 100.83 |
| 120010 | Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/ | 96,471,500.00 | 97,269,964.80 | -798,464.80 | 100.83 |
| 122 | Тусламжийн орлого | 1,331,173,600.00 | 1,159,517,039.49 | 171,656,560.51 | 87.10 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 1,331,173,600.00 | 1,159,517,039.49 | 171,656,560.51 | 87.10 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,475,321,300.00** | **1,196,608,348.65** | **278,712,951.35** | **81.11** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,475,321,300.00** | **1,196,608,348.65** | **278,712,951.35** | **81.11** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,379,613,900.00** | **1,100,901,026.98** | **278,712,873.02** | **79.80** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **880,894,900.00** | **819,290,048.71** | **61,604,851.29** | **93.01** |
| 210101 | Үндсэн цалин | 398,668,100.00 | 400,085,187.00 | -1,417,087.00 | 100.36 |
| 210102 | Нэмэгдэл | 292,999,900.00 | 280,355,804.21 | 12,644,095.79 | 95.68 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 64,277,900.00 | 48,441,520.79 | 15,836,379.21 | 75.36 |
| 210104 | Урамшуулал | 124,949,000.00 | 90,407,536.71 | 34,541,463.29 | 72.36 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **117,696,400.00** | **103,688,194.77** | **14,008,205.23** | **88.10** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 80,860,300.00 | 77,004,959.34 | 3,855,340.66 | 95.23 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,209,000.00 | 8,057,099.69 | 1,151,900.31 | 87.49 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,604,500.00 | 4,264,974.79 | 339,525.21 | 92.63 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,604,500.00 | 2,894,206.84 | 1,710,293.16 | 62.86 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 18,418,100.00 | 11,466,954.11 | 6,951,145.89 | 62.26 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **68,077,900.00** | **52,063,580.00** | **16,014,320.00** | **76.48** |
| 210401 | Бичиг хэрэг | 5,508,100.00 | 3,951,910.00 | 1,556,190.00 | 71.75 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 30,000,000.00 | 23,077,570.00 | 6,922,430.00 | 76.93 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,515,700.00 | 2,640,000.00 | 875,700.00 | 75.09 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 10,500,000.00 | 5,114,500.00 | 5,385,500.00 | 48.71 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 18,554,100.00 | 17,279,600.00 | 1,274,500.00 | 93.13 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2105** | **Нормативт зардал** | **168,241,600.00** | **61,054,239.50** | **107,187,360.50** | **36.29** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 126,441,600.00 | 40,112,689.50 | 86,328,910.50 | 31.72 |
| 210502 | Хоол, хүнс | 30,000,000.00 | 20,941,550.00 | 9,058,450.00 | 69.81 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **70,696,600.00** | **15,670,770.00** | **55,025,830.00** | **22.17** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 18,333,300.00 | 2,929,900.00 | 15,403,400.00 | 15.98 |
| 210602 | Тавилга | 19,000,000.00 | 3,440,000.00 | 15,560,000.00 | 18.11 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 16,500,000.00 | 3,356,000.00 | 13,144,000.00 | 20.34 |
| 210604 | Урсгал засвар | 16,863,300.00 | 5,944,870.00 | 10,918,430.00 | 35.25 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **9,500,000.00** | **7,190,000.00** | **2,310,000.00** | **75.68** |
| 210702 | Дотоод албан томилолт | 9,500,000.00 | 7,190,000.00 | 2,310,000.00 | 75.68 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **54,006,500.00** | **32,145,694.00** | **21,860,806.00** | **59.52** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 50,070,800.00 | 30,556,400.00 | 19,514,400.00 | 61.03 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,152,000.00 | 1,152,000.00 | 00.00 | 100.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 250,000.00 | 86,450.00 | 163,550.00 | 34.58 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 150,000.00 | 58,474.00 | 91,526.00 | 38.98 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 100,000.00 | 53,800.00 | 46,200.00 | 53.80 |
| 210807 | Газрын төлбөр | 80,000.00 | 32,570.00 | 47,430.00 | 40.71 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 2,203,700.00 | 206,000.00 | 1,997,700.00 | 09.35 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **10,500,000.00** | **9,798,500.00** | **701,500.00** | **93.32** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,500,000.00 | 9,798,500.00 | 701,500.00 | 93.32 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **95,707,400.00** | **95,707,321.67** | **78.33** | **100.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **95,707,400.00** | **95,707,321.67** | **78.33** | **100.00** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 54,151,400.00 | 54,151,321.67 | 78.33 | 100.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 41,556,000.00 | 41,556,000.00 | 00.00 | 100.00 |
| **8** | **ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ** | **-47,676,200.00** | **60,178,655.64** | | |
| **9** | **АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **47,676,200.00** | **-60,178,655.64** | | |
| **7** | Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | 47,676,200.00 | -60,178,655.64 | | |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00.00 | 47,676,233.23 | | |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00.00 | 107,854,888.87 | | |

**Орон нутгийн төсвийн гүйцэтгэл:**

төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | **НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО** | **48,670,300.00** | **47,266,353.51** | 1,403,946.49 | 97.1 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **БА ТУСЛАМЖИЙН ДҮН** | | | | |
| 12 | Татварын бус орлого | 48,670,300.00 | 47,266,353.51 | 1,403,946.49 | 97.1 |
| 122 | Тусламжийн орлого | 48,670,300.00 | 47,266,353.51 | 1,403,946.49 | 97.1 |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 48,670,300.00 | 47,266,353.51 | 1,403,946.49 | 97.1 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **48,670,300.00** | **47,266,353.51** | 1,403,946.49 | 97.1 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **48,670,300.00** | **47,266,353.51** | 1,403,946.49 | 97.1 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **48,670,300.00** | **47,266,353.51** | 1,403,946.49 | 97.1 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 48,670,300.00 | 47,266,353.51 | 1,403,946.49 | 97.1 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,647,900.00 | 4,244,209.51 | 1,403,690.49 | 75.2 |
| 210302 | Түлш, халаалт | 43,022,400.00 | 43,022,144.00 | 256.00 | 100.0 |
| 8 | **ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ** | - | - | - | - |
| 9 | **АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | - | - | - | - |
| 7 | Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | - | - | - | - |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 16,883.1 мянган төгрөгийн 8 алдаа, зөрчил илэрснээс, 7,683.8 мянган төгрөгийн 6 алдааг аудитын явцад залруулж, үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаж, үнэлгээг шинэчлэн тогтоох 1 зөвлөмж өгч, 9,199.3 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүллээ.

### 3.1.Залруулсан алдаа

- Жилийн эцсийн санхүүгийн тайланг бэлтгэж ирүүлэхдээ тайлант оны худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийг гаргаж ирүүлээгүй, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн маягтын дагуу тайланг бэлтгэж ирүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7 “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах;” заалттай нийцэхгүй “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул аудитын явцад нөхөж гаргасан.
- Төсөвт байгууллагын өөрийн орлогыг 287.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх” заалттай нийцэхгүй “толилуулга” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул аудитын явцад залруулгыг хийж, үнэн зөв толилуулсан.
- Барилгын засварын материалын дансанд 348.0 мянган төгрөгийн авто сэлбэгийн дансанд, 810.0 мянган төгрөгийн автомашины 3 ширхэг аккумляторыг аж ахуйн материалын дансанд бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх” заалттай нийцэхгүй “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул аудитын явцад залруулгыг хийсэн.
- Засварт зарцуулсан 1,948.0 мянган төгрөгийн барилгын болон автын сэлбэгийг зарлагадаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх” заалттай нийцэхгүй “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул аудитын явцад залруулгыг хийсэн.
- Тайлант жилийн эцэст эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангах зорилгоор 4,200.8 мянган төгрөгийн шатахууны мөнгө урьдчилж шилжүүлж, биетээр аваагүй шатахууныг орлогод авсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх” заалттай нийцэхгүй “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул аудитын явцад залруулж, урьдчилж гарсан зардлаар бүртгэсэн.
- Ээлжийн амралтын үед 90.0 мянган төгрөгийн хоолны мөнгө давхардуулан олгосныг дансанд тушаалгахдаа авлагын дансаар бүртгээгүй, үр дүнгийн тайланд орлогоор

хүлээн зөвшөөрч бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх” заалттай нийцэхгүй “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул аудитын явцад залруулсан.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 9,199.3 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 18,440.8 мянган төгрөгөөс бага байх тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

### 3.2. Албан шаардлага

1. Эрүүл мэндийн төвийн дарга, нягтлан бодогч нар нь 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан гэж урамшуулал авахдаа аудитын тайланд тусгагдсан алдаа, зөрчил болон санхүүгийн тайлангийн хугацаа, чанар, өр, авлага зэрэг шалгуур үзүүлэлтийг харгалзаж байх талаар өгсөн өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлээгүй
2. Төсвийн эдийн засгийн ангилал зөрчсөн 6,081.3 мянган төгрөгийн дараах гүйлгээг хийсэн нь төсвийг зориулалтын дагуу зарцуулах талаар өгсөн өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.
    - Цалин болон ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн бүлэг хооронд гүйлгэж 4,022.2 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн.
    - Хөдөлмөр хамгааллын зардлаас 1,435.5 мянган төгрөгийн нормын хувцасны мөнгө шилжүүлсэн.
    - Цалингийн зардлаас шилдэг ажилтны шагнал 623.6 мянган төгрөгийг тооцож олгосон нь төсвийн эдийн засгийн ангилал зөрчсөн байна.

Эдгээр зөрчил нь өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 заалтад заасан “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах;”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23.2 заалт, Сангийн сайдын 2012 оны 294 дүгээр тушаалаар баталсан журмын 5.1 заалтад заасан шалгуур үзүүлэлт, Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4 заалтад заасан “Үр дүнгийн гэрээний биелэлт, хэрэгжилтийн явц байдалд үндэслэн...”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3-р хавсралт “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 1.2.1 заалтад “төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчид;” мөнгөн урамшуулал олгохоор заасантай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байх тул зөрчил таслан зогсоох албан шаардлагыг хүргүүллээ.

### 3.3. Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал**

*<u>Илрүүлэлт</u>:*

Тус эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгийн бүртгэлд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн “тэг” үлдэгдэлтэй 44,475.8 мянган төгрөгийн анхны өртөг бүхий 96 хөрөнгө бүртгэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;”

## 5. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруу лаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Завсрын аудитаар** | | | | | | | | | | |
| Орлогыг зөрүүтэй тайлагнасан | 2 | 10,658.1 | | | 2 | 10,658.1 | 2 | 10,658.1 | | |
| Бараа материалын бүртгэл, тайлагналтай холбоотой | 5 | 43843.5 | | | 5 | 43843.5 | 5 | 43843.5 | | |
| Зардлыг зөрүүтэй тайлагнасан | 4 | 1,221.0 | | | 4 | 1,221.0 | 4 | 1,221.0 | | |
| Тайлангийн уялдаатай холбоотой | 1 | 2,929.9 | | | 1 | 2,929.9 | 1 | 2,929.9 | | |
| **Дүн** | **12** | **58,652.5** | | | **12** | **58,652.5** | **12** | **58,652.5** | | |
| **Жилийн эцсийн аудитаар** | | | | | | | | | | |
| Төсвийн гүйцэтгэлийн тайланг бүрэн бүрэлдэхүүнээр, батлагдсан маягтаар бэлтгээгүй. | 1 | - | 1 | - | | | 1 | - | | |
| Төсөвт байгууллагын өөрийн орлогыг зөрүүтэй тайлагнасан | 1 | 287.0 | | | 1 | 287.0 | 1 | 287.0 | | |
| Бараа материалыг холбогдох дансанд нь орлогод аваагүй | 1 | 1,158.0 | | | 1 | 1,158.0 | 1 | 1,158.0 | | |
| Засварт зарцуулсан материалыг зарлагаар бүртгээгүй. | 1 | 1,948.0 | | | 1 | 1,948.0 | 1 | 1,948.0 | | |
| Урьдчилж гарсан зарлагыг буруу бүртгэсэн. | 1 | 4,200.8 | | | 1 | 4,200.8 | 1 | 4,200.8 | | |
| Авлагыг үр дүнгийн тайланд орлогоор бүртгэсэн. | 1 | 90.0 | | | 1 | 90.0 | 1 | 90.0 | | |
| **Дүн** | **6** | **7,683.8** | **1** | **-** | **5** | **7,683.8** | **6** | **7,683.8** | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Эдийн засгийн ангилал зөрчиж гүйлгээ хийсэн, бүртгэлийн ажилтнуудад урамшуулал олгохдоо холбогдох шалгуур үзүүлэлтүүдийг харгалзаж үзээгүй, зөвхөн Зөрчилгүй" санал дүгнэлт авсан гэж урамшуулсан нь өмнөх оны аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. | 1 | 9,199.3 | | | 1 | 9,199.3 | | |
| Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийг ашиглалтын хугацааг сунгаж, үнэлгээг шинэчлэн тогтоох | 1 | - | | | | | 1 | - |
| **Дүн** | **2** | **9,199.3** | | | **1** | **9,199.3** | **1** | **-** |

**5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл:**

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | Аудитад хамрагдах | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | 1 | | | |
| | **НИЙТ** | **1** | **1** | | | **1** | | | |

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр № 65/А2270648/ХӨА-2026/060/НА-СТА-ТШЗ Мөрөн сум

*Зөрчил арилгах тухай*

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөвсгөл аймгийн Түнэл сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Төсвийн эдийн засгийн ангилал зөрчиж 6,081,250.17 төгрөгийн гүйлгээ хийсэн;
2. Эрүүл мэндийн төвийн дарга, нягтлан бодогч нар нь 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар "Зөрчилгүй" санал дүгнэлт авсан гэж 3,118,000 төгрөгийн урамшуулал авахдаа аудитын тайланд тусгагдсан алдаа, зөрчил болон санхүүгийн тайлангийн хугацаа, чанар, өр, авлага зэрэг шалгуур үзүүлэлтийг харгалзаагүй;
3. Дээрх зөрчлүүдэд өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т "Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж урамшуулж болно.", Сангийн сайдын 2012 оны 294 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуур журам"-ын 5.1-т "Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг бүрэн хөтөлж, улирлын болон жилийн санхүүгийн тайлан, тэнцэл, төсвийн гүйцэтгэлийн мэдээг цаг хугацаанд нь чанартай, бүрэн гаргаж, өр авлагагүй ажилласан төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчийг Сангийн сайдын тушаалаар батлагдсан "Төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнах журам"-ын дагуу шагнаж урамшуулна." гэж заасан шалгуур үзүүлэлтийг харгалзаж үзээгүй, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ." гэж заасантай нийцээгүй "үнэлгээ ба хуваарилалт", "нийцсэн бөгөөд зохистой байх "батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.*", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т "*аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол*" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн эдийн засгийн ангилал зөрчиж гүйлгээ хийсэн, өмнөх оны аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар[1]т ирүүлэх;

[1] Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, 303 тоот

6724001079

2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Түнэл сумын Эрүүл мэндийн төвийн дарга(Б.Гүндмаа), нягтлан бодогч (Х.Дуламсүрэн) нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

"ИХЭРМӨРӨН АУДИТ" ХХК-ИЙН

ЗАХИРАЛ Б.МЯДАГМАА